

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”

НЭГ.Товч танилцуулга

Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/52 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилж, гишүүд 2 дахь жилдээ ажилласан.

Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүн нягтлан бодогч Ж.Нямжаргал нь 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж өөр байгууллагад шилжин ажилласан тул Ёс зүйн дэд хороонд шинээр 1 гишүүнийг хамт олны саналаар нөхөн томилсон. 1 гишүүнийг томилохдоо байгууллагын нийт албан хаагчдаас google form ашиглаж санал авсан.

Ёс зүйн дэд хорооны 1 гишүүнийг нөхөн томилох санал асуулганд нийт 28 албан хаагч орж саналаа өгсөнөөс:

- 1.Э.Баасанням – 19 хүн
- 2.Д.Пүрэвзэхүү – 1 хүн
- 3.Б.Гансайхан – 1 хүн
- 4.О.Заяа – 1 хүн
- 5.О.Мөнхзул – 2 хүн
- 6.Т.Золзаяа – 1 хүн
- 7.Т.Уртнасан – 1 хүн
- 8.Д.Дашбаатар – 1 хүн
- 9.Э.Лхамсүрэнбаатар – 1 хүний санал авсан.

Э.Баасаннямд 19 ажилтан буюу ажилчдын 67,9% нь санал өгч байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилуулахаар хурлын тэмдэглэл хөтлөн, саналыг байгууллагын даргад хүргүүлсэн ба даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Б/54 дүгээр “Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилох тухай” тушаалаар нярав Э.Баасаннямыг дэд хорооны гишүүнээр томилж одоо 3 гишүүнтэй ажиллаж байна.

ХОЁР.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

2.1.1.Байгууллагын даргын 2021 оны 02 дугаар 26-ны өдрийн А/13 дугаар тушаалаар батлагдсан “Биеийн тамир, спортын газрын ажилчдын үйлчилгээний болон ёс зүйн стандарт”-ыг бүх ажилтан, албан хаагчдад өдөр бүр үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага МНС 7068:2025” стандартыг албан хаагчдад танилцуулах, албан ажилдаа хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын пэйж хуудас болон БТСГ-ын ажилчдын фэйсбүүк группт цахимаар дараах мэдээллийг сурталчлан ажилласан.Үүнд:

- Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль
- “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр
- Төрийн захиргааны албан хаагч болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийг албан хаагчдад танилцуулж ажиллалаа.

Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий төрийн захиргааны 4 албан хаагч 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Мөн байгууллагын А, Б зааланд мэдээллийн самбар шинээр хийж байршуулан албан хаагчдад мэдээ, мэдээллийг тухай танилцуулж, сурталчлан ажиллалаа.

Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүн Ч.Болдцэцэг (архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан ажилтан) Ёс зүйн хорооноос нэвтрүүлж буй “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” htm.csc.gov.mn цахим дэд системд дэд хорооны ажлын төлөвлөгөө, тайлан, албан хаагчдын мэдээлэл, бүртгэлийг тухай бүр оруулж байна.

Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06, 07, 08 дугаар тогтоолыг байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүд ажилчдын шуурхай хурал дээр болон БТСГ-ын фэйсбүүк группээр албан хаагчдад танилцуулж сурталчиллаа.

Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүд 2025 оны 12 дугаар сарын 01-20-ны өдрүүдэд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн

үнэлгээний хуудсын дагуу албан хаагчдаас эрсдлийн үнэлгээ авч дүгнэж ажилласан. Монгол улсын Ёс зүйн хорооны 2025 оны 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дагуу байгууллагын 30 албан хаагчаас албан тушаал тус бүрээр эрсдэлийн үнэлгээг авч гарын үсэг зурж баталгаажууллаа. Үүнд:

1. Дарга - 1
2. Спортын хэлтсийн дарга - 1
3. Биеийн тамирын хэлтсийн дарга - 1
4. Мэргэжилтэн - 9
5. Нягтлан бодогч - 1
6. Архив, бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан - 1
7. Нярав - 1
8. Биеийн тамирын зохион байгуулагч - 1
9. Сантехникч-цахилгаанчин, жижүүр - 1
10. Жолооч-жижүүр - 1
11. Жижүүр - 6
12. Үйлчлэгч - 2
13. Харуул - 4 ажилтан хамрагдлаа.

Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүд ажилчдын ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний судлагааг 06 дугаар тогтоолыг нэгдүгээр хавсралт "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал" -ын дагуу эрсдэлийг тодорхойлж эрэмбэлэн ангилахад дунд зэргийн эрсдэлтэй - 5 албан тушаал, бага эрсдэлтэй - 8 албан тушаал дүгнэгдсэн.

Үнэлгээний дүгнэлтийг нэгтгэн гаргаж байгууллагын даргаар хянуулж баталгаажуулсан ба цаашид эрсдэл бүрийн шалтгаанаас урьдчилан сэргийлж ажиллах арга хэмжээг албан хаагчдад авч ажиллаж байна.

2.1.2. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүд нь шинээр ажилд

2.1.2. Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн гишүүд нь шинээр ажилд орсон 3 албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан "Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль" болон Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг ажилд ороход нь танилцуулж цаашид өдөр тутам үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэг чиглэл өгсөн. Мөн бусад 30 ажилтанд байгууллагын шуурхайн хурал дээр 2 удаа танилцуулж, албан хаагчид өдөр тутам ажлын байрандаа мөрдөн хэрэгжүүлж, ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

2.1.3. Тайлант онд аймгийн Хууль, эрх зүйн хэлтэс, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран 4 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 33 албан хаагч хамрагдан мэдээ, мэдээлэл авсан. Үүнд: албан хаагчдын дунд

- 02 дугаар сарын 03-нд 2025 онд шинээр даган мөрдөж байгаа хууль, тогтоомжийг сурталчлах сургалтыг аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйч Б.Алтанзул, М.Эрдэнэт-Од нартай хамтран явуулж 22 албан хаагч идэвхтэй хамрагдсан. Зардалд 50,000 төгрөг

- 04 дүгээр сарын 09-нд байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүдтэй хамтран албан төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, танин мэдүүлэх зорилгоор "Ёс зүйн тухай хууль, тогтоомж, дүрэм, журмын мэдлэг, хандлага" сэдэвт АХА тэмцээнийг зохион байгуулж 3 багийн 18 ажилтан оролцсон. Зардал 50,000 төгрөг

Тэмцээний дараа ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, аймгийн хэмжээнд шинээр хөгжүүлж буй корнхоллын спортыг төрлийг сурталчлах зорилгоор корнхоллын тэмцээнийг зохион байгуулж аваргуудаа тодрууллаа.

-Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, ёс зүй сахилга хариуцлагыг чанаржуулах зорилгоор "Бүсчилсэн хөгжил - Төрийн албаны манлайлал" хойд бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн Орхон аймагт 04 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 5 албан хаагч оролцож төрийн албаны хууль тогтоомж, түүнтэй уялдаж гарсан журмуудын талаар мэдээлэл авсан.

- Байгууллагын Эцэг, эхийн зөвлөлтэй хамтран 05 дугаар сарын 07-нд албан хаагчдад "Гэр бүл-Харилцаа хандлага" сэдэвт сургалтыг Braints Knot кофе шофод зохион байгуулж 26 албан хаагч хамрагдлаа. Сургалтыг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын ажилтан Ц.Уянга удирдан явууллаа. Зардалд 30,000 төгрөг

Сургалтын үеэр Ёс зүйн зөвлөлийн гишүүд спортын хэлтэс, биеийн тамирын хэлтэс, аж ахуйн албанд "Хүний эрх хамгаалагчдад зориулсан хууль тогтоомж"-ийн эмхэтгэл өврийн номыг гардуулан өгч, тус номыг мэргэжилтэн, албан хаагчид уншиж судлан өдөр тутам албан хэрэгцээндээ мөрдөж ажиллахыг зөвлөлөө.

-06 дугаар сарын 13-ны өдөр АЗДТГ-ын Амарын танхимд зохиогдсон "Ажлын байран дахь эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал зуршил, хамт олны дотоод харилцаа, уур амьсгал"

сэдэвт сургалтанд шинээр ажилд орсон болон хүүхэд асрах амралтын хугацааны дараа ажилдаа орсон нийт 5 албан хаагч хамрагдлаа. “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS7068:2025 стандарт”-ыг бүх албан хаагчдад танилцуулж, сурталчилж ажилласан. Байгууллагын ажилчдад шинээр гарсан стандартыг танилцуулах, мэдээлэл өгөх зорилгоор 11 дүгээр сарын 13-нд Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн Л.Бямбажаргалтай хамтран зохион байгуулж 29 албан хаагч хамрагдан шинээр батлагдсан стандартын талаар мэдээллийг авлаа. Төрийн албаны зөвлөлөөс болон холбогдох байгууллагаас явуулж буй ёс зүйн холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын facebook группээр өгч шинээр гарсан хууль, Засгийн газрын тогтоол бусад эрх зүйн акт, дүрэм, журмуудын тухай мэдээллүүдийг тухай бүрд нь албан хаагчдад өгч хэрэгжүүлж ажиллалаа. Ажилтан, албан хаагчид удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг батлагдсан хуваарь, ажил үүргийн дагуу цаг тухай бүр хэрэгжүүлж ёс зүйн зөрчилгүй ажилласан. 2.1.4.Байгууллагын Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар пэйж хуудас, Орхон аймаг Биеийн тамирын хэлтэс, спортын хэлтэс фэйсбүүк групп, БТСГ-ын ажилчид фэйсбүүк группүүдэд Төрийн албаны зөвлөлөөс болон холбогдох байгууллагаас явуулж буй ёс зүйн холбоотой мэдээ, мэдээлэл, шинээр гарсан хууль, Засгийн газрын тогтоол бусад эрх зүйн акт, дүрэм, журмуудын тухай мэдээллүүдийг нийт 31 удаа байршуулж, албан хаагч, иргэдэд сурталчилж ажилласан. 2.1.6.Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүн Ч.Болдцэцэг (архив, бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан ажилтан) Ёс зүйн хорооноос нэвтрүүлж буй “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” hrm.csc.gov.mn цахим дэд системд дэд хорооны ажлын төлөвлөгөө, тайлан, албан хаагчдын мэдээлэл, бүртгэлийг тухай бүр оруулж байна. 3.1.1.Ажилтан, албан хаагчид удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг батлагдсан хуваарь, ажил үүргийн дагуу цаг тухай бүр хэрэгжүүлж ёс зүйн зөрчилгүй ажилласан. Тайлант манай байгууллагын ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, хувийн ашиг сонирхолтой холбоотой санал, гомдол ирээгүй болно. 4.1.1. Ёс зүйн дэд хорооны гишүүд 2025 онд жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах ажил, хийсэн ажлын биелэлт, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хэлэлцэж 3 удаа хуралдсан. Албан хаагчидтай холбоотой зөрчил, гомдол гараагүй. 5.1.1.05 дугаар сард Ёс зүйн зөвлөлийн гишүүд спортын хэлтэс, биеийн тамирын хэлтэс, аж ахуйн албанд “Хүний эрх хамгаалагчдад зориулсан хууль тогтоомж”-ийн эмхэтгэл өврийн номыг гардуулан өгч, тус номыг мэргэжилтэн, албан хаагчид уншиж судлан өдөр тутам албан хэрэгцээндээ мөрдөж ажиллахыг зөвлөлөө. Мөн ёс зүйн дүрэм, албан хаагчдын харилцаа, хандлага, зөрөг сэтгэлгээ сэдвээр 2 удаа гарын авлага бэлтгэж бүх ажилчдад өгч, танилцуулсан. 5.1.2.Байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх мэдээ, мэдээллийг тухай бүр албан хаагчдад танилцуулах зорилгоор А, Б зааланд мэдээллийн 2 самбар шинээр хийж байршуулан албан хаагчдад мэдээ, мэдээллийг тухай бүр сурталчилж байна. Тус самбарын зардалд нийт 60,000 төгрөг зарцуулсан. 6.1.1.Ёс зүйн дэд хорооны тайлант онд хийсэн ажлын тайлан болон зөрчлийн мэдээг гаргаж аймгийн ЗДТГ-ын ТАСЗ-ийн нарийн бичгийн дарга А.Өнөржаргал, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Цэрэннадмид нарт хугацаанд нь хүргүүлсэн. 2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал Байгууллагын дарга Д.Дэлгэрбаяр нь байгууллагын А, Б зааланд урсгал засвар үйлчилгээг өөрсдийн хүч, хөрөнгөөр хийлгэж өнгө үзэмжийг сайжруулж ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг тав тухтай болголоо. Албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах ажлын хүрээнд мэргэжилтэнгүүдэд орчин үеийн хүчийн чадал сайтай 2 компьютер, принтер 1, бусад тоног төхөөрөмжийг шинээр авч албан хэрэгцээнд хэрэглэж байна. Мөн ажилтан, албан хаагч, секцийн сурагчид, спортоор хичээллэгч иргэд, тамирчдын эрүүл мэндэд анхаарч А, Б зааланд шинээр 2 ус шүүгч сольж байрлуулан иргэдийн талархалыг хүлээж байна. Дарга Д.Дэлгэрбаяр нь удирдах ажилтны ур чадвар, ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж ёс зүй, сахилга, албан тушаалын зөрчил гаргаагүй албан хаагчдад үлгэрлэн ажилласан. 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаанд нь үнэн зөв мэдүүлсэн. 2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа Тайлант онд байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүд жилийн үйл ажиллагааны ажлын төлөвлөгөө гарган даргаар батлуулж 11 ажил зохион байгуулахаар төлөвлөн төлөвлөгөөг 100% хэрэгжүүлэн ажиллалаа. Байгууллагын даргын 2021 оны 02 дугаар 26-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “Биеийн тамир, спортын газрын ажилчдын үйлчилгээний болон ёс зүйн стандарт”-ыг бүх ажилтан, албан хаагчдад
--

өдөр бүр үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/19 дүгээр "Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох тухай" тушаал гарч Ёс зүйн дэд хорооны 3 гишүүнд улирал бүр мөнгөн урамшууллыг эхний 3 улиралд журмын дагуу олгосон.

2025 онд 3 дугаар улирлын байдлаар дэд хорооны гишүүдийн урамшуулалд нийт 6,480,000 төгрөгийг цалингийн сангаас зарцуулж урамшуулал олгосон.

Тайлант онд манай байгууллагын ажилтан, албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, хувийн ашиг сонирхолтой холбоотой санал, гомдол ирээгүй болно.

Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
-Тайлант онд байгууллагын албан хаагчид удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг батлагдсан хуваарь, ажил үүргийн дагуу цаг тухай бүр хэрэгжүүлж харилцаа, хандлага, ёс зүйн зөрчилгүй ажилласан.	-Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага, иргэнээс сургалт авах, шаардлагатай материалын хэрэгслэлийн төсөв хүрэлцээгүй байна.

Санал
-Төрийн албан хаагчдад зориулж аймгийн хэмжээнд харилцаа хандлага, зэрэг сэтгэлгээний сэдэвт сургалтыг зохион байгуулах; -Төсөв, санхүүгийн зардалыг шийдвэрлүүлэх;

БАТАЛГААЖУУЛАЛТ
ГАЗРЫН ДАРГА

2026.01. / 07 /

Д.ДЭЛГЭРБАЯР

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

2026.01. / 07 /

Д.ОДГЭРЭЛ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

2026.01. / 07 /

Ч.БОЛДЦЭЦЭГ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо (1)	Хувийн жин(2)
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт [3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх [4]		1	1	1
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	1
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	0,5
			Соён гэгээрүүлэх нөлөөлийн ажил зохион байгуулсан байдал [7]	0,5	0,5	0,5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал [8]	0,5	0,5	0,5
	Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал [9]		0,5	0,5	0,5	
Хэсгийн оноо				4	4	4
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (гарсан дүгнэлтийгн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	1
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал [11]		1	1	1
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажилагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал [12]		1	1	1
Хэсгийн оноо				3	3	3
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал [13]		1	1	1
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна.нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)		1	1	1
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	1
Хэсгийн оноо				3	3	3
Үнэлгээний нийт оноо, хувь				10	10	10